Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/332 дугаар албан бичгийн хавсралт

МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗРЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД УЛСЫН ХЭМЖЭЭНД ИЖ БҮРЭН СУДАЛГАА ХИЙЖ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

1	**Ажлын даалгавар боловсруулах үндэслэл**	Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, мөн хөтөлбөрийн 3.2.2.7-д “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монопол, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.1.18-д “Эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар бизнес эрхлэгчид шинээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох таатай орчныг бүрдүүлнэ. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлого хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан нь Бизнесийн орчинд гол нөлөө үзүүлдэг Өрсөлдөөн, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн салбарыг хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий эсэхийг судлан тогтоох үндэслэл болно. Энэ хүрээнд нэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д заасны дагуу 5 жилээс дээш мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаа хийх шаардлагатай байна.
2	**Зорилго, ач холбогдол**	Монополын эсрэг газрын чиг үүргийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлснээр тэдгээр хууль тогтоомжийг Монгол Улсын хөгжлийн түвшин, урт хугацааны хөгжлийн бодлогод

		нийцүүлэн шинэчлэх шаардлагатай эсэх талаар дүгнэлт хийх боломжтой болно. Хэрэв хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны үр дүнд хууль тогтоомжийн шинэчлэл шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд, түүний дагуу хууль тогтоомжийг шинэчлэх ажлыг эхлүүлэх үндэслэл бүрдэнэ. Үүний үр дүнд нийгэм эдийн засгийг дэмжих, иргэд болон аж ахуй нэгжийн эдийн засгийн болон бусад эрхийг хамгаалах, хангахтай холбогдох эрх зүйн орчин сайжирна.
3	**Гүйцэтгэх ажил**	Хууль тогтоомжийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д заасны дагуу 5 жилээс дээш мөрдөгдөж байгаа, Монополын эсрэг газрын чиг үүргийн хүрээнд хамаарах дараах хуулиудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлнэ. Үүнд: 1. Өрсөлдөөний тухай хууль /2010 он/ 2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль /2003 он/ 3. Зар сурталчилгааны тухай хууль /2002 он/ 4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /2023 он/ 5. Сонгуулийн тухай хууль /2015 он/ 6. Зөрчлийн тухай хууль /2020 он/ 7. Монгол хэлний тухай хууль /2015 он/ Судалгааг боловсруулахдаа дараах шаардлагуудад нийцүүлсэн байна. Үүнд: • Үнэлгээний шалгуурыг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх, • Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх; • Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны Дугаар 59 “Аргачлал батлах тухай” тогтоолын хавсралт, "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтлах. Өмнөх онуудад дээрх хуулиудыг үндэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд олон талаас дүгнэлт хийж, тухайн зохицуулалтын үр дагаварт үнэлгээ хийх.

		Хуулиудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлгээг холбогдох байгууллагад танилцуулах, хэлэлцүүлэх, тухайн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах, хамтран хэлэлцүүлэх.
4	**Хүрэх үр дүн**	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлснээр тэдгээр хууль тогтоомжийг Монгол Улсын урт хугацааны бодлогод нийцүүлэн шинэчлэх шаардлагатай эсэх талаар дүгнэлт хийнэ. Хэрэв хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны үр дүнд хууль тогтоомжийн шинэчлэл шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд, түүний дагуу хууль тогтоомжийг шинэчлэх ажлыг эхлүүлэх үндэслэл бүрдэнэ. Үүний үр дүнд нийгэм эдийн засгийг дэмжих, иргэд болон аж ахуй нэгжийн эдийн засгийн болон бусад эрхийг хамгаалах, хангахтай холбогдох эрх зүйн орчин сайжирна.
5	**Ажлын цар хүрээ**	Улсын хэмжээнд
6	**Гүйцэтгэх хугацаа**	4 сар
7	**Тайлагнах үе шат**	Эхний тайлан: ажлын төлөвлөгөө, судалгааны арга, аргачлал, цар хүрээг тодорхойлсон байна. Явцын тайлан: Нийт хуулиудын хэрэгжилтийн үнэлгээний үр дүнг урьдчилсан байдлаар гаргасан байна. Эцсийн тайлан: Гэрээнд заасан хуулиудын хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмжийг гаргасан байна.
8	**Төсөвт өртөг**	401,500,000 төгрөг
9	**Тавигдах шаардлага**	Зөвлөх баг нь дараах шаардлагуудыг хангасан байна. • Зөвлөх үйлчилгээг 10-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэнэ. • Зөвлөх багийн гишүүдийн 50-иас доошгүй хувь нь хууль эрх зүй, эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх нь давуу тал болно.

		• Зөвлөх багийн гишүүд хууль эрх зүйн болон эдийн засгийн ухааны докторын зэрэгтэй бол давуу тал болно. • Зөвлөх багийн гишүүд нь хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа хийж байсан туршлагатай бол давуу тал болно. • Зөвлөх багийн гишүүд нь нэрлэсэн хуулиудын зохицуулах харилцааны хүрээнд бүтээл туурвиж байсан бол давуу тал болно. Багийн ахлагч эсвэл дэд ахлагч нь дараах ажлын туршлагатай байх нь давуу тал болно. • Хэрэглэгчийн эрх, хүний эрхийн мэдрэмжтэй, өрсөлдөөн болон хэрэглэгчийн чиглэлээр эрдэм шинжилгээний ажил, сурах бичиг, онолын ном бичиж байсан бол давуу тал болно. • Мэргэжлээрээ 10-аас дээш жилийн ажлын туршлагатай, хуулийн төсөл боловсруулах ажил хийж байсан туршлагатай байх. • Хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай олон улсын туршлага судлах материалыг ашиглах, орчуулах англи хэлний мэдлэгтэй байх.
10	**Бусад нөхцөл, шаардлага**	Судалгааны багийн гишүүдээс 3-аас доошгүй гишүүн англи хэлний мэдлэгтэй байх.

---oOo---